

## “МОНГОЛ УЛСЫГ ГАДААДАД СУРТАЛЧЛАХ ХӨТӨЛБӨР” БАТЛАГДЛАА

Бичсэн hanoi

2016 оны 1-р сарын 06, Лхагва гариг, 01:53 - Сvvлд шинэчлэгдсэн 2016 оны 1-р сарын 06, Лхагва гариг, 01:58

---

Засгийн газрын энэ оны анхдугаар хуралдаанаар “Монгол Улсыг гадаадад сурталчлах хотолбор”-ийг баталлаа. Монгол Улсын гадаад бодлогын зорилгыг хэрэгжvвлэх гадаад сурталчилгааны чиглэлийг тодорхойлох, нэгдсэн зохицуулалттай, харилцан уялдаатай сурталчилгааны цогц механизмыг бий болгох, гадаад сурталчилгаа, соёлын харилцаагаар дамжуулан хоёр болон олон талын талын хамтын ажиллагаанд дэмжлэг vзvvлэхэд хотолборийн зорилго оршиж байна.

Монгол Улс аюулгvй байдлаа баталгаажуулах, оорийн улсын язгуур эрх ашгийг хамгаалах, олон улсын тавцанд байр сууриа бэхжvвлэх гадаад бодлогын зорилтоо зоолон хvчний (soft power) зарчмаар хэрэгжvвлэхэд илvv ач холбогдол огч байна. Зоолон хvч нь цэрэг зэвсэг, эдийн засгийн хvчээр давамгайлан шийдвэр гаргуулдаг хvчний тэнцвэр (balance of power)-ийн олон улсын харилцаанаас vндсээрээ ялгаатай богоод тухайн улсын ард тvмэн, тэдний vзэл бодолд оорийн улсын талаар зов мэдээллийг хvргэх гадаад сурталчилгаа юм.